



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/190

Чингис хот

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны Ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Буянсацрах" ХХК-ний эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар баг. Тариаланчдын гудамжинд байрлах худалдаа үйлдвэрлэлийн зориулалттай 3780 м² газрыг "Чингис органик хүнс" ХХК-д шилжүүлэн эзэмшүүлэхдээ бүрдүүлэх материал болох татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай цахим эсхүл хэвлэмэл тодорхойлолтыг дутуу бүрдүүлсэн байх тул аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/145 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

2. Захирамж хүчингүй болсонтой холбогдуулан газар эзэмших эрх шилжүүлэгч болон эрх шилжүүлэн авагч нар захирамжийг хүлээн авснаас хойш хуульд заасан 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА